



**ТӨВ АЙМАГ  
БҮРЭН СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ  
ТОГТООЛ**

2022 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 01

Төхөм

┌ Сумын 2023 оны төсөв батлах тухай ┐

Сумын 2023 оны төсвийн төсөл боловсруулсан тухай сумын Засаг даргын хийсэн мэдээлэл, өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцээд Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2, дахь заалт Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.9 дахь хэсэг, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын аравдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

**Нэг.** Сумын 2023 оны төсвийн орлогын нийт дүн, орлогын нэр төрлийн хэмжээг дор дурьдсанаар баталсугай:

Д/д	Байгууллага, орлогын нэр төрөл	ДҮН / мянган төгрөг /
	<b>Сумын төсвийн татварын орлого</b>	<b>271,800.0</b>
1.1.	1.1.1 Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад хувь хүний орлогын албан татвар	25,000.0
	1.1.2 Бууны албан татвар	900.0
	1.1.3 Улсын тэмдэгтийн хураамж	500.0
	1.1.4 Хадгаламжийн хүүгийн орлого	32,500.0
	1.1.5 Суутган-2 /ХХСОАТ/ байгууллагас	9,000.0
	1.1.6 ҮХЭХ борлуулсны албан татвар	4,000.0
	1.1.7 Ан агнах зөвшөөрлийн хураамж	19,000.0
	1.1.8 ҮХЭХ-ийн албан татвар	2,000.0
	1.1.9 Цалин хөлс ТАОАТ	131,000.0
	1.1.10 Буцаан олголт	( 15,000.0)
	1.1.11 Хог хаягдлын хураамж	2,900.0
	1.1.12 Малын тоо толгойн албан татвар	60,000.0
	<b>Сумын төсвийн татварын бус орлого</b>	<b>7,691.6</b>
1.2.	1.2.1 Түрээсний орлого	800.0
	1.2.2 Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсаны орлого, хүү, торгуулийн орлого	400.0
	1.2.3 Газрын төлбөр	6,491.6
	<b>Нийт дүн</b>	<b>279,491.6</b>

4122040120

**Хоёр.** Сумын 2023 оны төсөвт төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллага, бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг дор дурдсанаар баталсугай:

Д/д	ТТЗ, түүний харьяа байгууллага	Орлогын дүн /Мянган төгрөг/
2.1.	Сумын Засаг дарга	
2.1.1.	Харьяалах төсөвт байгууллагын өөрийн орлого	

**Гурав.** Сумын 2023 оны төсвийн жилд төвлөрүүлэх зарлагын нийт хэмжээг 1,507,285.5 мянган төгрөгөөр баталж төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа байгууллагад дор дурдсан төсөв зарцуулах эрх олгосугай.

<b>3.1.</b>	<b>Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга</b>	
3.1.1.	Урсгал зардлын хэмжээ Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	<b>97,521.1</b>
3.1.2.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал	<b>2,200.0</b>
<b>3.2.</b>	<b>Засаг дарга</b>	
3.2.1.1	Сумын Засаг даргын Тамгын газар	
	Урсгал зардлын дээд хэмжээ	488,238.8
	Үүнээс: Орон нутгийн байгууллагын байр ашиглалтын тогтмол зардал	75,414.5
	Орон нутгийн өмчийн арчилгаа, хамгаалалт, засвар үйлчилгээний төлбөр	19,000.0
3.2.1.2	Ерөнхий боловсролын сургууль	<b>188,154.7</b>
	Орон нутгийн өмчийн арчилгаа, хамгаалалт, засвар үйлчилгээний төлбөр	188,154.7
3.2.1.3	Сургуулийн өмнөх боловсрол	<b>39,164.6</b>
	Орон нутгийн өмчийн арчилгаа, хамгаалалт, засвар үйлчилгээний төлбөр	39,164.6
3.2.1.4	Соёлын төв	<b>23,537.8</b>
	Орон нутгийн өмчийн арчилгаа, хамгаалалт, засвар үйлчилгээний төлбөр	23,537.8
3.2.1.5	Эрүүл мэндийн төв	<b>38,580.5</b>
	Орон нутгийн өмчийн арчилгаа, хамгаалалт, засвар үйлчилгээний төлбөр	38,580.5
3.2.2	Хөрөнгийн зардлын дээд хэмжээ	<b>76,700.0</b>
3.2.2.1	Төсвийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ /шилжих үлдэгдэл/	76,700.0
3.2.3	Хөрөнгийн зардлын дээд хэмжээ	<b>458,273.5</b>
3.2.3.1	Төсвийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ /ОНХСан/	458,273.5

**Дөрөв.** Сумын 2023 оны төсвийн жилд төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зардлын хэмжээг 76,700.0 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зардлын хэмжээг 458,273.5 мянган төгрөгөөр тус тус баталсугай.

**Тав.** Сумын 2023 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,507,285.5 мянган төгрөг буюу дор дурдсанаар баталсугай:

5.1. Сумын татварын болон татварын бус орлого 279,491.6 мянган төгрөг.

5.2. Сумын төсөвт аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 752,820.4 мянган төгрөг.

5.3. Сумын төсвийн урьд оны үлдэгдэл 76,700.0 мянган төгрөг.

5.4. Сумын орон нутгийн хөгжлийн санд аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлэг 367,499.3 мянган төгрөг.

5.5. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн шилжих үлдэгдэл 30,774.2 мянган төгрөг

**Зургаа.** “Орон нутгийн шилжих үлдэгдэлийн жагсаалт”-ыг нэг дүгээр хавсралтаар Орон нутгийн хөгжлийн сангаар 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоо болон хэмжээний үзүүлэлт”-ийг гуравдугаар хавсралтаар, “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын жагсаалт”-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

**Долоо.** Сумын 2023 оны төсвийн хэрэгжилтийг хангах зорилгоор дараах арга хэмжээг авч ажиллахыг сумын Засаг дарга /Т.Түвшинбат/-д даалгасугай.

7.1. Сумын төсвийн сар, улирлын хуваарийг бодитой хийж, төсвийн орлого, зарлагын мэдээ, улирлын тайланд дүн шинжилгээ хийж гүйцэтгэлийн явцад хяналт тавьж, доголдож буй ажилд анхаарал хандуулж, эрчимжүүлэх арга хэмжээг цаг алдалгүй авч өны эхнээс жигд ханган төрийн үйлчилгээний тасралтгүй хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх.

7.2. Төсвийн байгууллага, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулан, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах.

7.3. Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зохион байгуулахгүй байж, холбогдох зардлыг хэмнэх.

7.4. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1. дэх хэсэгт заасны дагуу төлөвлөж, зорнулалтын дагуу захиран зарцуулахад онцгойлон анхаарах.

**Найм.** Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Эдийн засаг, төсөв санхүү, өмчийн бодлогын хороод үүрэг болгосугай.

ДАРГА



С.ЭНХТҮВШИН